



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2022 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/142

Алтанбулаг

**Бүх нийтээр мод тарих арга хэмжээг  
зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1, 31 дүгээр зүйлийн 31.1, 31.2, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлиг, Засгийн газрын 2021 оны “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 350 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар тогтоол, “Сэлэнгэ аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 6.3.2, 6.3.7, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 13 дугаар тогтоол “Аймгийн Засаг даргын 2021-2024 оны хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.2.1, 5.1.2, 5.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн “Бүх нийтээр мод тарих арга хэмжээг зохион байгуулах тухай” А/380 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд “Бүх нийтээр мод тарих арга хэмжээ”-г 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрөөс 10 дугаар сарын 09-ний өдрийн хооронд иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг өргөнөөр оролцуулан зохион байгуулсугай.

2. Арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

Нарийн бичиг :

Гишүүн:

Х.Отгонжаргал  
(Засаг даргын орлогч)

Г.Март  
(Байгаль хамгаалагч)

Ж.Эрдэнэцогт  
(Бэлчир Бүсийн Сум Дундын  
Ойн Ангийн дарга)

З.Амарсайхан  
(Байгаль хамгаалагч)

Э.Зориг  
(1 дүгээр багийн Засаг дарга)

Н.Мөнхзул  
(2 дугаар багийн Засаг дарга)

Г.Мөнхболд  
(3 дугаар багийн Засаг дарга)

3. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний эрчимжүүлж, мод тарих, арчлах ажлын үр дүнг дүгнэж, төгөл, цэцэрлэгт хүрээлэн, мод үржүүлгийн чиглэлээр иргэд, аж ахуйн нэгжээс гарч буй санал санаачлагыг дэмжиж, тарьц, суулгацын борлуулалт, нийлүүлэлтийг нэмэгдүүлэхийг анхаарч ажиллахыг Бэлчир бүсийн сум дундын ойн ангийн дарга (Ж.Эрдэнэцогт)-д үүрэг болгосугай.

4. Мод тарих газрыг сонгон үр тарьц суулгацаар ханган хуваарь, маршрут гарган нийтийн эзэмшлийн зам талбайн дагуу сум орон нутгийнхаа онцлогт тохируулан зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг ажлын хэсгийн дарга Засаг даргын орлогч (Х.Отгонжаргал)-д даалгасугай.

A red square stamp containing Mongolian text. The text is arranged in a grid-like pattern, likely a table or list. A handwritten signature in black ink is written over the stamp.

Н.ОТГОНЦОГТ